

ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

*Нийгмийн даатгалын сангийн
чөлөөт үлдэгдлийг санхүүгийн
хэрэгсэлд оруулах тухай*

2026 оны 05 дугаар сарын 26

Нийгмийн даатгалын ерөнхий газраас 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 01/1367 дугаартай албан бичгээр Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын албаар уламжлан ирүүлсэн хүсэлт, хавсралт баримт материалуудтай Мэргэжлийн хорооны гишүүд танилцаж, 2026 оны 05 дүгээр сарын 26-ны өдрийн хуралдаанаар хэлэлцээд дараах дүгнэлт, зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

1. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13,1 дэх хэсэг, Монгол улсын Засгийн газрын 2024 оны 254 дүгээр тогтоолоор батлагдсан журмын хүрээнд нийгмийн даатгалын сангуудын чөлөөт үлдэгдлээс 2025 онд системийн нөлөө бүхий арилжааны банкуудад 700,0 тэрбум төгрөгийг эрсдэлгүй байршуулж, уг санг 105,0 тэрбум төгрөгийн хүүгээр арвижуулсан нь сайшаалтай байна.

2. Нийгмийн даатгалын ерөнхий газраас арилжааны 5 банканд 545,0 тэрбум төгрөгийг мөнгөн хадгаламж хэлбэрээр нэг жилийн хугацаатай байршуулах саналын тухайд Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь заалт, Засгийн газрын 2024 оны 254 дүгээр тогтоолоор батлагдсан “Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах журам”-ын 6 дахь хэсгийн 6.4.2-т заасан шалгууруудыг хангасан, эрсдэл багатай гэж үнэлэгдэж байгаа тул Мэргэжлийн хороо дэмжих нь зохистой гэж үзэв.

3. Нийгмийн даатгалын ерөнхий газраас ирүүлсэн танилцуулгаас үзэхэд тэтгэмжийн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн чөлөөт хуримтлалаас 2026 онд 302,0 (847,0-545,0) тэрбум төгрөг эргэлтэд орж, мөнгөний мөн чанараа хадгалах боломж нь хуулийн зохицуулалтаар хязгаарлагдсан байна. Хязгаарлалтад орсон дээрх хөрөнгийн эргэлтээс 30 гаруй тэрбум төгрөгийн хүүгийн орлого олох боломж хаагдаж, мөн ийм хэмжээний ханшийн уналтын эрсдэл хүлээх нөхцөл бүрджээ. Иймд Мэргэжлийн хорооноос 2026 оны 04 дүгээр сарын 27-нд өгсөн зөвлөмжийн 3 дахь хэсэгт анхаарал хандуулж эрх зүйн зохицуулалтыг яаралтай хийлгэхийг дахин зөвлөмж болгож байна.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН
ДЭРГЭДЭХ МЭРГЭЖЛИЙН ХОРОО